Б.ЭРДЭНЭЧИМЭГ-БХЭШХ-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН, ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР, ДЭД ХУРАНДАА

П.МӨНХБААТАР-ҮБХИС-ИЙН ДОКТОРАНТ

## ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Ардчилал, эрх чөлөө, эв нэгдэл зэрэг нь ард түмний эрхэмлэх ёстой үнэт зүйлс билээ. Манай улсын хувьд үндэсний эв нэгдэл алдагдан хуваагдалд орох эрсдлүүд буй хэмээн улс төр, нийгэм судлаачид үздэг. Энэ хуваагдал нь яс үндэс, нутаг ус, нийгмийн гарал байдал, амьжиргааны болон боловсролын түвшин, намын болон шашны харъяалал, үзэл бодол, өмч, орлого, эрх мэдэл зэрэг олон зүйлээр илэрч байна.

Ийм эмзэг үед үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлын гол гогцоо нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх явдал болж байна. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд Монголын төр засаг, намууд, улс төрчид, иргэн бүр үндэсний язгуур ашиг сонирхлоо дээдлэн хамгаалж байх нь нэн чухал байна.

Үндэсний эв нэгдэл бол нийгмийн болон соёлын бүлгүүдийг нэгтгэхэд хувь нэмэр оруулах үйл явц юм. Үндэсний нэгдмэл байдал нь нийгмийн дэг журмыг бий болгох, түүний үндсэн болон суурь үзэл баримтлал, үнэт зүйлсийг хөгжүүлэхэд тусалдаг. Үндэсний хэмжээнд эв нэгдэл нь улс орны тогтвортой байдлыг бэхжүүлж, хөгжил цэцэглэлтийг дэмжиж, үндэстнээ нэптэх үйл явц юм. Эв нэгдэл нь нэг талаас нийгэм, соёлын нэгдмэл байдлыг бий болгох замаар хүчирхэг, нэгдмэл улс байгуулах үндэсний ашиг сонирхол дээр тулгуурладаг.

Үндэсний эв нэгдэл нь үндэсний тогтвортой байдалд чухал ач холбогдолтой бөгөөд тогтвортой байдал нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж өгдөг.

Аливаа улс оронд үндэсний эв нэгдэл яагаад чухал вэ гэдэг асуултад хариулахдаа нийгэм судлаачид дараах дөрвөн үзэгдэлийг онцолсон байдаг.[1]

Үндэсний эв нэгдэл улс оронд баттай тогтсоноор:

1. Үндэстэн, ястан хоорондын сөргөлдөөн тэмцэл багасч, нэг улс оронд амьдарч буй өөр өөр үндэстэн, ястангуудын хооронд эв найрамдал бий болдог.
2. Эх оронч сэтгэлгээг бий болгодог. Өөр өөр үндэстэн ястны нэг төлөөлөл гэхээс илүүтэйгээр нэг улс орны иргэн гэдгээ ойлгож, эх орноо хайрладаг.
3. Энх тайван байдал бий болно. Үр дүнд нь улс орныхоо өнцөг булан бүрт тайван амгалан ажиллаж, амьдрах боломж хүн бүрийн өмнө нээгддэг.
4. Өөр өөр угсаатан, ястангууд хоорондоо гэр бүл болохыг дэмждэг. Энэ нь үндэсний эв нэгдэлийг илүү ахисан түвшинд гаргаж, бэхжүүлж байдаг.

Үндэсний эв нэгдэлийг бэхжүүлэх үндсэн үзэл баримтлал нь:

1. Үндэсний нэгдмэл байдал нь өөр өөр угсаатан, ястан, шашны бүлгүүд хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын зорилт юм.
2. Нэгдмэл байдал нь нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйлс, эрх ашиг бүхий нэгдмэл бүлгийг бий болгох үйл явц юм.
3. Үндэсний эв нэгдлийн үзэл баримтлал нь нийгэм, улс орныг бүхэлд нь үндэсний үзэл баримтлалаар нэгтгэх үйл явц бөгөөд ингэснээр иргэдэд нийтлэг эрхэмлэдэг зүйлс, нийтлэг үнэт зүйлст хамаарах мэдрэмжийг бий болгож чадна.

1. Social Studies by Simiyu Wandibba, pp. 231-233.

4. Төрөөс интеграцийн гурван үндсэн ойлголтыг нийгэмд ойлгуулах хэрэгтэй ба энэ нь соёлын нэгдмэл байдал, хамтын ажиллагаа, олон ургальч үзэл юм.

Үндэсний эв нэгдэл нь эх оронч үзэл дээр суурилдаг. Эх оронч үзэл нь ард түмнээ нэгтгэж, улс орныхоо сайн сайхны төлөө хамтран ажиллахад урам зориг өгч дэмждэг юм. Үндэсний эв нэгдэл нь соёл, нийгэм, бие махбод, хэл шинжлэл, шашин шүтлэг, улс төр, үзэл суртал, сэтгэл зүйн олон ялгаатай байдгаас үл хамааран эв нэгдлийг бий болгоход чиглэдэг.

**ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ БЭХЖҮҮЛЖ БАЙДАГ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС**

Даяаршиж буй өнөө үед цагаачлал, эдийн засгийн хямрал, зэвсэгт мөргөлдөөн, шашин хоорондын зөрчил зэрэг олон хүчин зүйлсийн улмаас дэлхийн улс орнууд үндэсний эв нэгдлээ хангахыг аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгон, улмаар ард түмнийг нэгтгэдэг шинэ үндэсний онцлог хэв шинж, үнэт зүйлийн эрэлд мордоод буй. Европын орнуудад цагаачид, дүрвэгчид олноор суурьшснаар үндэсний эв нэгдлээ хангахын тулд “олон ургальч” байдлыг эрхэмлэсэн шинэ үнэт зүйлсийг эрэлхийлэх болсон бөгөөд уламжлалт “зан заншил”, “шашин” зэрэг үндэсний онцлогоос илүүтэй өөр өөр шашин шүтлэг, арьс өнгө, угсаа гаралтай, өөр өөр хэлээр ярьдаг хүмүүсийг нэгэн улс оронд эв нэгдэлтэй амьдрах үнэт зүйлийг бүтээх, дэлгэрүүлэхийг эрмэлзэж байна. Улс үндэстнүүд дотоодын эвдэрэл, хагарал, зөрчил, мөргөлдөөнөөс зайлсхийх, улмаар улс үндэстнээ хамтын хүчээр хөгжүүлэн урагшлуулахад нэгдмэл үнэт зүйлтэй байх нь чухал тул цагаачид, дүрвэгчид, олон үндэстэн угсаатнаас бүрдсэн улс орнууд үндэсний онцлогоо шинээр тодорхойлоход хүрч байна.

Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд үндэсний онцлог хэв шинжийг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Үндэсний хэв шинжийг бүрдүүлж чадаагүй тохиолдолд угсаатны, нийгмийн давхаргын, бүлгийн гэх мэт хэв шинж давамгайлж нийгэмд хуваагдал, задрал үүссээр байх болно. Монгол хүн иргэний хувьд ямар байх, ямар боловсрол хүмүүжилтэй байх, амьдралын ямар хэв шинж, үзэл бодолтой байх, ямар мөрөөдөл тэмүүлэлтэй байх талаар нэгдсэн ойлголт бүрдээгүй, үндэсний нэгдмэл ухамсар, үзэл санаа дутмаг байна. Монгол хүн өнгөрсөн түүхээрээ бахархахын зэрэгцээ ирээдүйд чиглэсэн хүсэл эрмэлзлэлтэй байх ёстой бөгөөд үүнд төрийн, ялангуяа боловсролын салбарын бодлого, үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

“Үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгарах онцлог (national identity) гэдэг нь аливаа хүн аль нэг улс орон эсвэл үндэстэнд харъяалагддаг гэх хувь хүний мэдрэмж, өвөрмөц, онцлог шинж байдал юм”* [2] хэмээн тодорхойлсон байдаг. Сэтгэл судлалын ухааны өнцгөөс харвал өөр ялгаатай байдлаа мэдрэх, “тэд”-нээс ялгарах “бид" хэмээх нэг бүлэгт хамааруулах хандлагатай байдаг.

Үндэсний эв нэгдэлд нөлөөлөгч хамгийн чухал хүчин зүйлсийн нэг нь Үндэсний онцлогоо дээдлэх явдал бөгөөд шинжлэх ухаан технологийн дэвшил хурдацтай хөгжин даяаршиж буй өнөөгийн нийгэмд нэгдмэл, нэг үнэт зүйлтэй байх нь улс орны эв нэгдлийг бэхжүүлж байдаг.

АНУ-ын Вашингтонд төвтэй Пев судалгааны төвөөс гаргасан судалгаагаар улс үндэстнийг нэгтгэж байдаг үндэсний ижилсэл буюу Дэлхийн хаана ч явсан би “Монгол хүн", би “Америк хүн” гэж тодотгож байдаг тэрхүү үндэсний онцлог гэдэгт дараах 4 зүйлийг хамруулж судалгаа хийжээ. Үүнд:

- Эх хэл
- Үндэсний зан заншил, өв уламжлал

2. Ashmore, Richard D.; Jussim, Lee; Wilder, David, eds. (2001). *Social Identity, Intergroup Conflict, and Conflict Reduction.* Oxford University

- Төрсөн газар орон
- Итгэл үнэмшил буюу шашин зэргийг хамруулсан

Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь аливаа үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа юм. Улс үндэстнийг нэгтгэн зангидаж байдаг үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгах тэрхүү онцлог нь хэл, бичиг, үндэсний соёл, өв уламжлал, зан заншил хэмээн ерөнхийлөн тодорхойлж болох юм. . Аливаа улс үндэстнийг нэгтгэн зангидаж байдаг үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгах тэрхүү онцлог болох хэл соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалан хамгаалж үеийн үед өвлүүлэн уламжилж, үргэлж бахархан дээдэлж явах нь үндэсний аюулгүй байдлын гол тулгуур болох үндэсний эв нэгдлийг хангахад чухаг ач холбогдолтой юм.

Өөр өөр гарал угсаа, хэл соёл, шашин шүтлэг, амьдралын хэв маягтай үндэстэн угсаатангууд нэг улсын газар нутагт, эх орноо гэсэн нэг итгэл үнэмшилийн дор үндэсний эв нэгдлээ эрхэмлэн хамтдаа оршин тогтноход хэл, боловсрол, хууль, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс нөлөөлдөг.

**ХЭЛ-ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ:**

Эв нэгдэлийг бэхжүүлэхэд тухайн улс орны төрөлх хэл амин чухал байдаг. Өнгөц харахад үндэсний эв нэгдэл хэмээх ойлголт нь ард иргэдийг удирдах улс төрийн нэгэн арга хэрэгсэл мэт боловч нөгөө талдаа нэгдмэл нийгмийг бий болгож байдаг дотоод бодлогын салшгүй хэсэг юм.

Тогтвортой байдал үгүй болох аюул аль ч нийгмийн өмнө тулгарч байдаг учраас саад бэрхшээлгүйгээр сайхан улс, нийгмийг байгуулна гэж байхгүй. Энэхүү бэрхшээлүүдийг даван туулахад үндэсний хэл амин чухал.

Хэлний үүргийг дөрвөн үндсэн хэсэг болгон ангилдаг[3].

1. Танин мэдэхүйн үүрэг
2. Нөлөөллийн хэрэгсэлийн үүрэг
3. Нэгтгэх үүрэг
4. Соёлын үүрэг

Хэл нь улс үндэстэн нэгдмэл болон бүрэлдэх үйл явцын үед үндэсний эв нэгдэлийн чухал элемент болохоос гадна нийгэм болон улс төрийн элемент болдог. Нийгэм, улс төрийн үйл явцад хэл нь олон янз байдлаар нөлөөлөл үзүүлдэг. Тухайлбал шинэ улс нийгмийг нэгтгэхийн тулд харь хэлнээс үлгэрлэж авсан Индонез(саармагхэл)хэл, Еврей үндэстний анхны бичиг үсэг боловч тодорхой хугацаанд бүдгэрч, одоо ахин сэргээд буй, үндэсний эв нэгдэлийн гол түлхүүр болсон еврей хэл, Польш улс улс төрийн хувьд газрын зурагнаас арчигдсан мөчид усталгүй, тэсэн үлдэж Польшийн нийгэмтэй холбогдох чухал үүргийг тээж явсан польш хэл гээд олон олон нөхцөлбайдалдэвнэгдлийнзангилааболсонүндэснийхэлнүүдийнтодорхойжишээнүүдбайдаг.

**БОЛОВСРОЛ - ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ:**

Боловсролын систем нь аливаа улс үндэстэний эв нэгдэлийг бэхжүүлэх, ирээдүйн удирдагчдыг бэлтгэх, ажиллах хүчнийг сургах, өөр өөр шашин, хэл, соёл бүхий үндэстэн ястангуудыг нэгтгэхэд чухал нөлөөтэй байдаг[4]. Боловсрол нь нэг ойлголт, нэг санааг

**3. Anna Grzywacz (2013),** *The Role of Language in Nation-Building Process,* **Warsaw University,** https://jlt-polinema.org/?p=284

4. *The Journal of Modern African Studies, 5,3 (1967),* pp.323-324 **"Education and National Integration in Nigeria"** Alan Peshkin, Cambridge University Press (1967)

системтэйгээр олон нийтэд түгээж байдаг учраас аль ч улс сургуулийн боловсролоор дамжуулж өөрсдийн ирээдүйн иргэдээ нэгдмэл үзэл санаатай болгон бэлтгэж байдаг.

**ХУУЛЬ-ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ:**

Нэг хуулийн доор захирагдаж байгаа олон үндэстэн ястан нэг улсын иргэд болж, ирээдүйгээ бүтээж, нэг зорилгын төлөө зүтгэж чаддаг. Хуулинд бүх хүний эрх ашгийг багтаасан, үзэл санааг нэгтгэсэн зохицуулалт байдаг учраас үндэсний эв нэгдэлийг хангагч гол хүчин зүйл юм. Тухайлбал Монгол Улсын Үндсэн Хуулинд доорх ойлголтуудыг багтаасан байдаг.

*"Монголын ард түмэн бид":*

Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,-эх *орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол* Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ . МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ**

**Нэгдүгээр зүйл.**

*1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.*

*2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал,* үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

**Хоёрдугаар зүйл.**

*1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.*

*2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.”*[5]

Үндсэн хуулинд улс орон бүрэн бүтэн, нэгдмэл орших бүхий л зарчмуудыг тусгаж өгсөн байдаг нь үндэсний эв нэгдэлийн гол элемент юм.

**ЭДИЙН ЗАСАГ - ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ:**

Эдийн засгийн тогтвортой байдал нь тухайн оронд амьдарч буй иргэдийн амар тайван байдлыг бий болгож байдаг. Эдийн засгийг хөдөлгөгч хүчний нэг нь ажиллах хүч буюу тухайн улсын иргэд. Хүн бүр амар тайван, эв найрамдалтай, эрүүл энх амьдрахын тулд анхан шатны хэрэгцээгээ (хоол, орон байр, үр хүүхдээ тайван орчинд өсгөх) хангах шаардлагатай. Хэрэв анхан шатны хэрэгцээгээ хангаж чадахгүй бол тухайн нийгэмд амьдралын төлөөх тэмцэл үүсч эмх замбараагүй нөхцөл байдал үүсдэг. Тиймээс эдийн засгийн тогтвортой байдал нь улс үндэстний эв нэгдэлийг хангаж байдаг гол элемент юм.[5] [6] Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:

-  Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь_эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн. Эдийн засгийн олон

5. Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 оны 1 сарын 13, Улаанбаатар хот
6, Problems of National Unity; Historical and Economic Roots of Regionalism (1984) Social scientist

тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцын асуудлаар оновчтой бодлого баримтлана.[7]

Эдийн засгийн зөв бодлогыг улс орондоо амжилттай хэрэгжүүлж, иргэдээ нэгтгэж чадсан улсын гол төлөөлөл бол Сингапур улс юм.[8]

Дэлхийн II дайнаас өмнө Англи улсын тэнгисийн цэргийн баазыг байрлуулж байсан, намгархаг жижиг арал дээрх байгалийн баялаг байтугай ундны ус ч байхгүй, Хятад, Малай, Энэтхэг зэрэг олон үндэстнээс бүрдсэн энэ жижиг хотыг тухайн үед олон улсын бодлого тодорхойлогчид Английн цэрэг гарч явсны дараа товчхондоо «баларна» гэж үзэж байв. Хөрш зэргэлдээ Малайз, Индонез улсууд Сингапурыг эрхэндээ оруулахыг хичээж байв. Гэвч энэ хот улсын түүх Ли Куан Ю хэмээх хүний ачаар капиталист болон коммунист хөгжлийн загвараар бус, өөрийн онцлогтой өвөрмөц замаар хөгжин цэцэглэсэн юм. Байгалийн баялаггүй энэ хот улс дэлхийн хамгийн баян орнуудын нэг болж, улс төр, шинжлэх ухаан, өндөр технологийн төв, дэлхийн худалдааны чухал зангилгаа болсон юм.

Ли Куан Ю 1959 онд Сингапурын ерөнхий сайд болж, хамгийн түрүүнд ард иргэдээ нэгдэн нягтрахыг, дараа нь улс орондоо эмх журам тогтоож, гар хумхилгүй ажиллахыг уриалж эхэлсэн байдаг. Сингапурын амжилтын бас нэг чухал зарчим бол эдийн засгийн хөгжлийн үр шимийг ард иргэддээ шударгаар хуваарилах явдал гэж тайлбарлажээ. Энэ нь халамж тараах гэсэн үг биш бөгөөд Сингапур улс тогтвортой ажлын байр бий болгох, ажил хийж буй хүн бүрийг хуримтлалтай болгох, айл өрх бүрийг орон сууц, хувьцаа эзэмшигч болгох, эрүүл мэнд, боловсролын чанар, амьдрах орчныг дэлхийн түвшинд аваачих зэргээр бодит өөрчлөлтөөр хөгжлийн үр шимийг ард иргэддээ хүртээж чадсан байна. Ли Куан Ю дандаа үндэсний эрх ашиг, ард иргэдийн эрх ашиг, урт хугацааны, тогтвортой хөгжлийг чухалчилж байсан нь «Сингапурын гайхамшиг» бий болоход нөлөөлжээ. Түүнийг улс орноо удирдсан жилүүдэд ажлын байр тасралтгүй нэмэгдэж, улмаар улс орон нь баян болж, хүн амынх нь амьдралын түвшин дэлхийн хамгийн баян орнуудынхтай зэрэгцэж очсон юм.

Сингапур бол эдийн засгийн тогтвортой хөгжлийн үр шимээр эв нэгдэлээ бататгаж чадсан хүчирхэг улсын тод жишээ юм. "Сайн удирдагч, хүчирхэг эдийн засагтай улсын иргэд гадагшаа цагаачилдаггүй, тэд эх орондоо сайхан амьдарч чаддаг" гэж Ли Куан Ю дурсамжийн номондоо бичиж үлдээсэн байдаг.

**НИЙГЭМ-ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ:**

Аливаа улс орны нийгмийн бодлого гагцхүү хүндээ чиглэж, тухайн орны хөгжил цэцэглэлт нь ч хүний хөгжлөөс шууд хамаардаг.[9] Төрийн бодлогын энэ салбарт эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучууд зэрэг нийгмийн бүх бүлэг давхраaг хамарч, нийт хүн амд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг багасгах гээд өргөн хүрээтэй, олон асуудлыг

7. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

8. "Сингапурын гайхамшиг"-ийн эцэг, тус улсын анхны ерөнхий сайд асан Ли Куан Югийн дурдатгал "Сингапурын хөгжлийн нууц", Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн түүх

9. Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгэм - тогтолцоо ба бодлого (2013 он), "Нийгмийн бодлого", Доржготов Наранцэцэг (Ph.D) проф, х. 81-103.

багтаадаг. Нийгмийн бодлого гэдэг нь нийт улсын болон бүс нутагт нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн шинжтэй бүх талын үйлчилгээг иргэдэд үзүүлэх, хүн амын нөхөн үржихүйн болон амьдралын хэвийн нөхцөлийг хангахтай холбоо бүхий төрийн бодлогын өргөн хүрээтэй салбар, чиглэлийг нэгтгэн илэрхийлсэн ойлголт мөн. Аливаа улс орон нийгмийн бодлогоороо дамжуулан НҮБ-ын хүний эрхийн түгээмэл Тунхаг болон Үндсэн хуулиараа тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх нийгмийн баталгааг бүрдүүлэхийг зорьж байдаг. Иймээс улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдаж байнга өөрчлөгдөн боловсронгуй болж байх ёстой. Өөрөөр хэлбэл, тодорхой нөхцөл байдалд үндэслэн нийгмийн бодлогыг тодорхойлоод хэрэгжүүлэх явцдаа үзүүлэлтүүдийг хянах, үнэлж дүгнэх, энэ үндсэн дээрээ өөрчлөн сайжруулж байх боломжтой байдаг. Нийгмийн амьдрал улам нэгдмэл цогц шинжтэй болж байгаа нь хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны чиглэлийг олон талтай, бас цогц байхыг шаардаж байна. үр дүнтэй байдаг. Иргэн бүрт нийгмийн бодлогын үр шим хүрч чадаж байвал тухайн нийгэм, улс орон тогтвортой хөгжиж эв нэгдэл батжиж байдаг.